

## ДАЙН ГАРАХ ШАЛТГААН: ТҮҮНИЙГ СУДЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ГУРВАН ТҮВШИН

Д. Бүдсүрэн<sup>1</sup>

**Я**агаад дайн гэж? Хэдэн зууны туршид уг асуудлаар судлаач шинжээчид маргасаар байна. Философичид, агуу удирдагчид болон нийгэм судлаачид дайн гарах шалтгааны тухай хэд хэдэн онол дэвшүүлээд байна. Эдгээр онолууд нь ганцхан үндэстэй дайны шалтгаануудыг гаргаж ирж болох боловч хүн төрөлхтөн яагаад байлддагт ганц ч шалтгаан байхгүй байдагтай холбоотой юм. Үүнээс үзэхэд дайны олон шалтгааныг авч үзэх ганц арга нь шинжилгээний гурван түвшнээр ангилан авч үзэх явдал юм. Үүнд:

1. Тогтолцооны түвшний анализ
2. Улс орны түвшний анализ
3. Хувь хүний түвшний анализ

### *Тогтолцооны түвшний дайны шалтгаан*

Дэлхийн улс төрийн тогтолцооны ерөнхий байдалтай холбоотой хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан дайн үүсдэг байж болох юм. Үүнийг тайлбарлахын тулд дөрвөн өөр тогтолцооны түвшинг авч үзье.

- **Хүчний тархац:** Түүхийг эргэн санавал шинжээч, судлаачид олон улсын харилцааны тогтолцоонд дайн байлдаан болох хандлага нь хүчний туйлуудын (их гүрнүүдийн) тоо хэмжээ, тэдний эргэн тойрны дэмжигч хүч болон хүчний туйл нь тогтвортой байна уу, байнгын өөрчлөгдөж байна уу гэдэгтэй холбоотой гэж үзэж болно. Жишээлбэл, энэхүү тогтолцоонд олон улсын хараилцаанд буй хүч ихсэх, багасч буурах, зарим нь бүр устаж үгүй болох гэх мэт чухал ач холбогдолтой хүчний шилжилт өөрчлөлт эргээд хүчний сул орон зайг үүсгэдэг. Үүний эсрэг тал нь сул орон зайг авах гэх мэт зөрчил мөргөлдөөнийг үүсгэдэг. Тиймээс дайны дараа ялж, хүч төвлөрсөн гол холбоотон орнуудыг зарим талаараа дайнд ялагсан гэж үзэж болно.

- **Эмх замбараагүй байдал:** Зарим судлаачид ямарваа улс оронд зөрчил мөргөлдөөнөөс сэргийлэх, эсрэг хүчнээс хамгаалах төвийн эрх мэдэл байдаггүйгээс дайн байлдаан болж байдаг гэж үздэг. Олон улсын байдлаас улбаалан зарим нэг улс орны дотоод нийгмийн байдлаас ялгаатай нь хууль батлах, түүний хэрэгжилт, шүүх зэрэг нь ямар ч үр нөлөөгүй тогтолцоо болж хувирдагт оршино. Яг л ийм аюултай байдлыг үүсгэдэг болохоор бусад орнууд зэвсэгт хүчинтэй болж хүч хэрэглэдэг тул ямар ч улс орон үүний эсрэг зэвсэг хэрэглэх шаардлага урган гардгаас энэ нь зэвсэглэлээс тайван бус байдал, тайван бус байдлаас зэвсэглэл гэсэн “хурцадмал байдал”-ын тойргийг буй болгож, хүч хэрэглэдэг ажээ.

- **Эдийн засгийн хүчин зүйл:** Байгалийн баялгийн хэрэглээ, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг нь зөрчил мөргөлдөөнийг үүсгэж буй нэгэн хүчин зүйл болдог. Үүний

<sup>1</sup> МУИС-ийн ОУХС-ийн багш



тод жишээ нь 1990 онд Ирак гол байгалийн баялаг болох нефть, түүний боловсруулалтаас болж Кувейт руу довтолж, Саудын Арабыг айлган сүрдүүлсэн явдал юм. Энэ үед АНУ тэргүүлсэн Арабын орнуудаас газрын тосны хувьд хараат байдаг улсууд Саудын Арабыг хамгаалж, Кувейтыг чөлөөлөхөөр болсон Ойрхи Дорнод руу довтолсон нь 1991 онд Персийн булангийн дайныг дэгдээсэн юм. Өөр нэгэн эдийн засгийн хүчин зүйл нь баян болон буурай орнуудын хоорондын зөрчилдөөн юм. Судлаачид бүс нутаг болон улс орнуудын баялгийн жигд бус тархац бол тоо нь харьцангуй нэмэгдэж буй ядуу буурай орнуудын дургуйцлийг хүргэж, хойд, урд тэнхлэгийн дагуу зөрчил мөргөлдөөнийг үүсгэж байгааг судлан мэджээ. Үүнээс харахад терроризмын уул уурхай өмнөдөд бий болсон нь баян хоосны ялгаанаас шалтгаалсан байгаа юм.

- Агаар мандал буюу биосферийн хэт их ачаалал: Агаар мандлын нөөцийг хэтрүүлэн зарцуулж байгаа явдал зөрчил үүсгэж буй бас нэгэн түвшин болжээ. Жишээ нь усны нөөц. Чандмана эрдэнэ болсон ус нь маш олон газар орнуудад хамгийн нандин зүйл болоод байгаа бөгөөд усны нөөцнөөс болж зарим орнууд удахгүй мөргөлдөөн үүсгэж, дайн гаргаж болзошгүй болоод байна.

### ***Улс орны түвшний дайны шалтгаан***

Дайн улс үндэстний мөн чанараас шалтгаалж болно. Улс орны дотоод үйл явц, нөхцөл байдалтай холбоотой дайны хэд хэдэн онолын асуудал бий.

Цэрэгжилт. Улс үндэстэн цэрэгжүүлэх үзлийг өвлөн авах хандлагатай байна гэдэгт зарим эрдэмдэт итгэдэг. Ийм үзэлтэй нэгэн шинжээч “цэргийн үндсийг анхаарч үзэхгүйгээр орчин үеийн улс төрийн мөн чанарыг ойлгох боломжгүй” гэж бичсэн байдаг. Дайн байлдаан, цэрэг эрс, үнэ цэнэтэй зэр зэвсэг шаарддаг болохоор хүн ам олонтой, томоохон эдийн засагтай улс төрийн хэсгийн хэрэгцээ шаардлагыг үүсгэдэг гэсэн маргаан бий. Энэ нь тухайн улсын байр суурийг өргөж өгдөг.

Дотоод мөн чанарын гаднах мөн чанар. Заримдаа засгийн газар энгийн ардыг цуглуулах, орон нутгийн асуудлаас анхаарлыг сарниулахын тулд дайнд оролцдог. Ийм тоглолтыг сарниулах дайн буюу дотоод зөрчлийг гадагшаа гаргах гэж нэрлэнэ. Тухайлбал, хувьсгалын дэглэм бусад орнуудын хүчийг өдөөн хатгах хэлбэрээр өөрсдийн хүчийг бэхжүүлэхийг оролдож байна гэдгийг баримт харуулж байна. Мөн улс орнууд эдийн засгийн хямралд орох үедээ дайн тулаанд илүүтэй орж байна гэдэг нь бас нэгэн төлөв юм. Дастин Хофманы гол дүрд тоглосон “Нохой сүүлээ шарвах” кинонд гардаг ишиг удирдагчид хүчээ алдаж болно гэдгээс айхдаа тэд олон улсын хямралын гол дүрд тоглох гэж хичээж эхэлдэг.

Улс орны ангилал. Зарим улс орнууд өөрийн улс төрийн бүтэц (ардчилсан, авторитат) буюу эдийн засгийн баялаг нөөцөөсөө хамааран бусдаасаа түрэмгий байдаг гэж үздэг.

Улс төрийн соёл. Улс үндэстний улс төрийн соёл нь дайнч зан чанартай нь холбоотой гэж тодорхойлогддог. Ямар ч үндэстэнд төрөлхийн улс төрч шинж чанар байдаггүй ч тэдгээр улс үндэстнүүд хүч хэрэглэх замаар улс төрийн соёлоо хөгжүүлж байсан туршлага байгаа нь дэлхий ертөнцийг дайнч орчин гэж үзэхэд хүргэдэг. Тиймээс төр нь хэрхэн зохион байгуулагдсан, тэдгээр хоорондын дайн, зөрчил тэмцлийг зохицуулах бодлогоо хэрхэн боловсруулж байсан гэдгийг жагсааж тоочих нь чухал биш юм.

### ***Хувь хүний түвшний дайны шалтгаан***

Дайны шалтгаан нь удирдагчийн хувийн зан чанар эсвэл тухайн хүний төрөлх мөн чанараас хамааралтай байж болно. Нэг судлаач бичихдээ: “Эцсийн дүнд дайны тухай эргэцүүлэн бодоход дайны болон түүхийн барагдашгүй зовлонгийн эх ундрага нь хүн төрөлхтний мөн чанар” юм гэжээ. Хүний зан чанарт олдмол туршлага зонхилдогоос гадна хүний анхны үүсэлтэй шинж чанарын хувьд холбоотой гэдэг үзэлд итгэдэг хэсэг байдаг. Түүнчлэн хувь хүний зүгээс л нутаг дэвсгэртэй болох, байгаа бол түүнийгээ тэлэх хүслэн нь өнөөх л боломжит төрөлх араншин бөгөөд нутаг дэвсгэртэй холбогдсон маргаан үе үе дайны шалтгаан болж байсан баримт



түүхэнд олон. Өөр нэгэн боломжит байдал нь зарим нийгмийн сэтгэл зүйчдийн маргадгаар стресс, сэтгэл гутрал, сэтгэл зовнилоос үүдэлтэй уур хилэн, бие даасан болон нэгдэх эсвэл тусгаарлах үзэл юм. Үүний нэг жишээ нь Дэлхийн I дайны дараах өөрийн ялагдал, доромжлолд үзүүлсэн Германы нийгмийн хариу үйлдэл юм.

### **Цэргийн хүчийг хэт чухалчлах аюул**

Цэргийн хүчийг үндэсний батлан хамгаалах, дипломат ёсны арга хэрэгсэл хэмээн ач холбогдол өгөх нь “хэт их цэргийн хүч” хэмээх үзлийг бий болгодог бөгөөд энэ нь оксюморог байх ёстой гэж үздэг хүмүүст тийм ч энгийн асуудал биш. Яг тийм байх нь хангалттай гэж үзэх нь ярвигтай. Гэвч цэргийн хүчийг хэт чухалчлахтай холбоотой тодорхой аюул занал бий гэдэг нь тодорхой байна. Ийм төрлийн гурван эрсдлийг тусгайлан нэрлэж болох бөгөөд эдгээр нь тогтвортой бус байдал, уруу татахуй болон зардлын ухагдахуун юм.

Цэргийн хүч тогтвортой бус байдлыг бий болгодог. Хүч хуримтлуулах нэг үр дагавар нь “тогтвортой бус байдлын эргүүлэг” юм. Энэ аюулгүй байдалд хүрэх буюу тийм зүйлд хүрэхийн тулд тэмцэж буй бидний оролдлого бусдын нүдэнд аюул занал мэт санагдана хэмээх утгыг илэрхийлнэ. Бидний заналхийлэл гэж үзсэн “**тэнцвэржүүлэх хүчийг**” эзэмшихийг оролдож эхлэх бөгөөд ингэснээр бид илүү их хүчийг эзэмших, дараагаар нь тэд, дараагаар нь бид гэх мэтээр эцэс төгсгөлгүй үргэлжилж эргүүлэгт орно. Зэвсэглэлгүй болгох тухай асуудал нь зэвсэглэлээр хөөцөлдөхөөс илүү маш төвөгтэй үзэгдэл боловч нэг улс орны хүчний харилцаа нөгөө улс орны тогтвортой бус байдал зэрэг нь улс төрд чухал хүчин зүйлс болно.

### **Цэргийн хүч уруу таталтыг бий болгоно**

Цэргийн хэт их хүчийг хуримтлуулахын 2 дахь эрсдэл нь үндэсний ашиг сонирхлыг тойрсон нөхцөлд ашиглаж болох уруу татах үйл ажиллагаа юм. Ерөнхийлөгч Линдон Жонсон “ноорхой илжиг дөрөв дэх зиндааны улс” гэж хэлсэн баримт байгаа боловч АНУ Вьетнамд дайн зарласан. Вьетнамын хэрэгт америкчууд хөндлөнгөөс оролцсон нэг шалтгаан бол хүчний дээрээлхүү зан хэмээхээс үүдэлтэй. АНУ-ын цэргийн хүч даруухан байсан бол АНУ дипломат ёсыг магадгүй онцлон Хойд болон Зүүн Вьетнамын эргэн нийлэлтийг хүлээн зөвшөөрч болох байсан. Хэн нэгэн хэзээ ч итгэхгүй ч танд буу байхгүй бол хэн нэгнийг буудах нь боломжгүй болох нь тодорхой.

### **Цэргийн хүч зардал ихтэй**

Өөрийн төлөө хүчийг эзэмшихийн гурав дахь асуудал бол зардал маш өндөр байдагт оршино. Орон нутгийн болон батлан хамгаалахын хөтөлбөрийг хэрэгжүүлэх богино хугацааны төсвийн шийдвэр, тооцоогоо хэрхэн төлөх вэ гэдгээс гадна ерөнхий, урт хугацааны асуудал бий. 1900-1980-аад онд их хүчний уналтын үеийг судалж байсан нэгэн эрдэмтэн “эзэн хааны хэт нөлөө” тэдний уналтын шалтгаан байсан гэж дүгнэсэн. 1988 онд хийгдсэн Кеннедигийн судалгаа өнгөрсөн үеийн супер хүч олон их сурвалжийг цэргийн хүчинд нэгтгэж, цаашилбал, улс орны дэд бүтцийг сайжруулахад чиглэгдэх ёстой нөөцийг шилжүүлж улс орны хүчин чадлыг доройтуулсан. Кеннедигийн судалгаанд Зөвлөлт холбоот улсыг оруулаагүй бөгөөд цэргийн хүчинд хэт их зардал гаргасан нь ЗСБНХУ-ыг задрахад хүргэж, улс орны эдийн засгийг доройтуулсан гэдэг нь маргаантай байдаг. АНУ “эзэн хааны хэт нөлөөний үзэл”-д буруутан нь бөгөөд мандан бадарч, тэргүүлж, дараа нь уналтанд орж буй бусад агуу хүчнүүдийн замаар замнаж чадна гэдгийг урьдчилан сануулж байна.

### **Ном зүй:**

1. David W. Ziegler, *War, Peace and International Politics*, 6<sup>th</sup> ed.
2. *Politics Among Nations*, 4<sup>th</sup> ed. (New York: Alfred A. Knopf, 1967), p.31
3. Bernard Brodie, *War and Politics* (New York: Macmillan, 1973), p.289
4. Richard J. Barnet, *Roots of War* (New York: Atheneum, 1972), p.36
5. “The Element of Decision in the Pattern of War”, *American Sociological Review* Vol. 6, No 6 (December 1941), pp. 853-859